



BULLETIN

The IAMS News Information on Mongol Studies


2000
2000

No1 (25)
No2 (26)

In This Issue:

- L. Khurelbaatar The Tibetan Language Culture and
Literary Criticism of the Mongols
- Chu Ch'ae-hyok «Siyan» of «Ju Siyan-Siyanbi» Reindeer
Nomads
- Sumyabaatar A Manuscript by Academician
Luvsanvandan
- J. Uchralt In Search of «Chinos» Tribe
- Kim Hag Sung In Studies Suffix Possesive Pronouns
in Modern Mongolian
- News & Information
- Jubilee of Scholars
- Book Reviews
- New book
- Official documents
- A List of new books on Mongol Studies

The Secretariat of the International Association for Mongol Studies
Ulaanbaatar, Mongolia



Академич Лувсанвандангийн нэгэн гар бичмэлийн тухай

Марал овогт Сумьяабаатар (Монгол)

ᠬ Академич Лувсанвандангийн гар бичмэл энд тэнд гүй байдаг гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ толилуу лан буй гар бичмэл бас өөрийн гэсэн онцлогтой гэж бо дож байна: нэгдүгээрт, энэ нь цорын ганц хувь бичмэл; хоёрдугаарт, урьд хожид эл бүрэн эхээрээ, гарын үсгийн хамт огт хэвлэгдээдүй; гуравдугаарт, энэ 2000 онд уул гар бичмэлийн 50 жилийн ой болох юм. Тухайлбал, Лувсан вандан багш 1950 оны 7 сарын 15-нд бичиж гарын үсгээ зуржээ: дөрөвдүгээрт, Монголын Ринчен Лувсанвандан гэ дэг агуу их хоёр хүн ном хаялцсан агуулга нь хойч үе ийн бидэнд, ер монголын хэлшинжлэлийн ухааны түүхэнд юу юунаас үнэтэй, сонин байна; тавдугаарт, академич Лув санвандангийн энэ шүүмж өгүүлэл утга санаа гүн гүнз гий, үг хэллэг нуржуу бич, яруу тод байгаагаараа өвөр мөц юм. Энэ өгүүлэлд, академич Ринченгийн бичсэн <Мон гол хэлний зүйн бичиг> гэдэг зохиолыг “Монгол хүн, монгол хэлний зүйг орчин цагийн хэлний шинжлэлийн ар гаар биеэ даан шинжилж мөн монгол үг хэлээр зохиосон анхны зохиол”, “урьдах монголч нарын санал онолыг мух раар даган дуурнагаагүй, шинэ шинэ тайлбар оруулж шинэ шинэ саналыг зоригтой тавьсан, монгол хэлний шинжлэлд маш сонин, үнэтэй, шинэ том бүтээл болсон” байна гэж дүгнэхийн сацуу, үгсийн аймгийн тухай, үйл үгийн цагийн тухай, өгүүлбэрийн зүйн зарим асуудалд цаашид дахин дахин бодуштай зүйл байгаа тухай санал аа дэлгэр бичсэнийг эхийн гэрэл зураг, галиг сийрүү лэг ба монгол кирилл үсгийн буулгалаас үзнэ үү.

ᠬ Галиг сийрүүлэг:

[nigedüger niγur]

- [1] Rinčein γuwai-yin Jokiyaysan mongγol
- [2] kelen-ü Jüi-yin bičig-ün tuqai
- [3] Mongγol kümün, mongγol kelen-ü Jüi-yi orčein
- [4] čaγ-un kelen-ü sinčilel-ün arγ-a-bar bey-e-ben
- [5] daγayan sinčilejü mön mongγol üge kele-ber
- [6] Jokiyaysan mongγol kelen-ü sinčilel-ün Jokiyal
- [7] egün-ü emün-e nigečü γaruγadui bayγsan anu medegeji
- [8] -yin kereg bile.
- [9] Rinčein γuwai ene sayiqan ner-e-tei törü-tei ačil-i
- [10] eng terigün kičei. Rinčein γuwai-yin Jokiyaysan
- [11] mongγol kelen-ü Jüi-yin bičig dotur-a-ban dörben

[12] anggi bölüg-tür qubiyaydaısan anu:
[13] 1) uduridqal-un bölüg-tür mongyol biëig üsüg-ün
[14] teüke, mön mongyol kelen-ü olan ayalıu-yin
[15] toyımu-yi ögüleJei.
[16] 2) abıyan-u Jüi-yin bölüg. Egün-e qalq-a-yin
[17] abıyan-u Jüi-yi mongyol biëig-ün kelen-ü abıyan-u
[18] Jüi-tei qarsiyulun ögüleJei.
[19] 3) üge-yin Jüi. Egün-e mongyol kelen-ü üge
[20] bütükü-yin yosu-yi ögüleJei.

[qoyaduyar niyur]

[1] 4) ögülebüri-yin Jüi. Egün-e mongyol kelen-ü
[2] ögülebüri bütükü-yin goul toyımu-yi ögüleJü
[3] mön ÷ig temdeg kereglekü tuqai qabsurıyJai.
[4] egün-eëte üJekü-dü enekü mongyol kelen-ü Jüi-yin
[5] biëig, mongyol kelen-ü Jüi, biëig üsüg-ün
[6] ündüsün ÷iqula asaıyudal-i töm-i qamuruısan yeke
[7] tomu aJil boluısan anu ilerkei bayın-a.
[8] Rinëin yuwai, enekü mongyol kelen-ü Jüi-yin
[9] biëig-i bolbasurayulqu-dayan kelen-ü sinJilel-ün
[10] ÷iqula ÷iqula ner-e tomıy-a-yi sayitur bolbasurayulju
[11] mongyol kümün-ü, mongyol üge kele-ber-ben[iyen]
[12] törülki kelen-ü-ben yosu Jüi-yi sudulqu-duni
[13] üge kele-yin Jebseg-tei bolıyJai.
[14] Basa enekü biëig-tür mongyol kele biëig-i
[15] sudulqu uqayan-u bui boluısan ÷ay-aëta inaıysiki
[16] bükü olulta-yi angqarun bayıayaısan-ıyar ülü
[17] barum uridaki mongyolëi nar-un sanal onul-i
[18] muqur-ıyar dayan dayuriyal ügei, edüi tedüi
[19] Jüyil-dü ilangıuy-a üge-yin Jüi, üge-yin
[20] yarul-un sudulul, ögülebüri-yin Jüi-dü sin-e

[yurbaduyar niyur]

[1] sin-e tayılburı oruyulju sin-e sin-e sanal-i
[2] Joriy-tai talbiısan bayın-a.
[3] Egün-eëte yadan-a Rinëin yuwai-yin Jokıyaısan
[4] mongyol kelen-ü Jüi-yin biëig, barımta-bar
[5] ması bayalıy bolju uul barımta-yi ÷uyıayulqu-dayan,
[6] üy-e üy-e-yin mongyol kelen-ü ÷uqum silideg
[7] sayıqan Jisiy-e-yi silıyayulun tegübürileJü ÷ıdayısan
[8] anu uridaki mongyolëi nar-un Jokıyal-du üJegdegedüi
[9] amJilta geJü bolun-a.
[10] Rinëin yuwai basa enekü mongyol kelen-ü Jüi-yin
[11] biëig-degen üy-e üy-e-yin mongyol nayırayulıy-a,
[12] orëiyulıy-a-yin kelen-ü sayın maıy-yi qarsiyulun
[13] sudulju maıy dutaydal-tai nayırayulıy-a orëiyulıy-a-yi
[14] qayır yam ügei sigümJilegsen inü prayıtik yeke
[15] qolıyaydal uëir-tai bolJai.
[16] Enëi ü-ber Rinëin yuwai-yin Jokıyaısan
[17] mongyol kelen-ü Jüi-yin biëig yerüngkei-degen
[18] mongyol kelen-ü sinJilel-dü ması sonin, ün-e-tei
[19] sin-e tomu bütügel bolJai.
[20] Gebeëü Jarım Jüyil-dü ilangıuy-a üges-ün ayımaı-un

[dörbedüger niγur]

- [1] tuqai, üyile üge-yin ɛaγ-un tuqai, mōn
 [2] ögülebüri-yin Jüi-yin Jarim asaγudal-du ɛinaγsida
 [3] dakin dakin boduγusitai Jüyil bayimar sanaγdan-a.
 [4] Jisiyelbel, Rinɛin γuwai γurban ɛaγ-un
 [5] ilγamJiy-a-yi γarγaqu-daγan
 [6] a. önggeregsen ɛaγ
 [7] 1) önggeren tegüsügsen ɛaγ. daγaburi -ba, -bai
 [8] 2) önggeren ürgülJilegsen ɛaγ. daγaburi -Juqui.
 [9] e. edüge ɛaγ
 [10] 1) edüge tegüsügsen ɛaγ. -luγ-a.
 [11] 2) edüge tegüsügedüi ɛaγ. -mui
 [12] i. iregedüi ɛaγ
 [13] 1) ɛuquм iregedüi ɛaγ -n-a, -nam
 [14] 2) γaruɛaγ-a ügei iregedüi ɛaγ -yu kemen ilγajai.
 [15] InggeJü ilγaysan anu ɛuquм mongγol klassig biɛig-ün
 [16] kelen-ü ɛaγ, qalq-a-yin ayalγu-bar ündüsülegsen
 [17] orɛin ɛaγ-un mongγol kelen-ü ɛaγ qoyar-un
 [18] alin bolqu anu todurqai ügei bayin-a. Mongγol
 [19] klassig biɛig-ün kelen-ü ɛaγ getel-e -n-a gekü
 [20] metüɛilen orɛin ɛaγ-un mongγol yariyan-u kelen-ü
 ɛaγ-un daγaburi
 [tabuduγar niγur]
 [1] -yi oruγulJai. Orɛin ɛaγ-un mongγol yariyan-u kelen-ü
 [2] ɛaγ getel-e -mui, -yu gekü metüɛilen klassig biɛig
 [3] -ün kelen-ü ɛaγ-un daγaburi-yi oruγulJai.
 [4] kele-yi sinJilekü-dü tuqai-yin kelen-ü kögJijü
 [5] iregsen teüke-yi qarγalJaqu anu kelen-ü sinJigeɛin
 [6] kümün-ü ɛiqula Jüyil-ün nige mōn bolbatu
 [7] kele bol nigen keb-iyer ködelüsi ügei bayidaγ
 [8] ügei ürgülJi qubiran ögerɛilegdeJü bayidaγ
 [9] tula kelen-ü teüken grammatik, orɛin ɛaγ-un
 [10] nigen kelen-ü grammatik-un qoγorundu Jörigüü-tei
 [11] Jüyil Jayilasi ügei γarqu uɛir tere büri-yi
 [12] qamiγ-a ügei qudγun nigedgebel ɛuquм үнен
 [13] mōn inü medegdekü ügei budaliyantaqu(buduliyantuqu)
 -aɛa γadan-a
 [14] kerbe ene Jarɛim-i baγ-a dumdadu surγaγuli-du
 [15] üJekü orɛin ɛaγ-un mongγol kelen-ü Jüi-dü
 [16] barimtalbal mongγol-un sin-e udq-a Jokiyal-un
 kele-yi
 [17] örgen olan-u yariyan-u kelen-eɛe ketürkei
 qoladaγulqu
 [18] ayul-du kürgeJü kimel sinJitei bolγaju
 [19] bolqu tula, ene tal-a-bar bolγomJilaqu kereg-tei.
 [20] 1950 on. 7 duγar sar-a-yin 15
 [21] Ša. Lubsangwangdan

ᠮᠣᠩᠭᠣᠯ кирилл үсгийн сийрүүлэг

[Нэгдүгээр нүүр]

[1] Ринчин*¹ гуайн зохиосон монгол

- [2] хэлний зүйн бичгийн тухай
[3] Монгол хүн, монгол хэлний зүйг орчин
[4] цагийн хэлний шинжлэлийн аргаар биеэ
[5] даан шинжлэж мөн монгол үг хэлээр
[6] зохиосон монгол хэлний шинжлэлийн зохиол
[7] үүний өмнө нэг ч гараадүй байсан нь мэдээж
[8] ийн хэрэг билээ.
[9] Ринчин гуай^{*2} энэ сайхан нэртэй төртэй ажлыг
[10] эн тэргүүн хийжээ. Ринчин гуайн зохиосон
[11] монгол хэлний зүйн бичиг дотроо дөрвөн
[12] анги бөлөгт хуваагдсан нь:
[13] 1) удиртхалын бөлөгт монгол бичиг үсгийн
[14] түүх, мөн монгол хэлний олон аялгууны
[15] тоймыг өгүүлжээ.
[16] 2) авианы зүйн бөлөг. Үүнээ халхын
[17] авианы зүйг монгол бичгийн хэлний авианы
[18] зүйтэй харшуулан өгүүлжээ.
[19] 3) үгийн зүй. Үүнээ монгол хэлний үг
[20] бүтэхийн ёсыг өгүүлжээ.

[Хоёрдугаар нүүр]

- [1] 4) өгүүлбэрийн зүй. Үүнээ монгол хэлний
[2] өгүүлбэр бүтэхийн гол тоймыг өгүүлж
[3] мөн цэг тэмдэг хэрэглэх тухай хавсрагажээ.
[4] Үүнээс үзэхэд энэхүү монгол хэлний зүйн
[5] бичиг, монгол хэлний зүй, бичиг үсгийн
[6] үндсэн чухал асуудлыг цөмийг хамарсан их
[7] том ажил болсон нь илэрхий байна.
[8] Ринчин гуай, энэхүү монгол хэлний зүйн
[9] бичгийг боловсруулахдаа хэлний шинжлэлийн
[10] чухал чухал нэр томъёог сайтар боловсруулж
[11] монгол хүний, монгол үг хэлээрээ
[12] төрөлхи хэлнийхээ ёс зүйг судлахад нь
[13] үг хэлний^{*3} зэвсэгтэй болгожээ.
[14] Бас энэхүү бичигт монгол хэл бичгийг
[15] судлах ухааны буй болсон цагаас янагших
[16] бүх ажилтыг анхааран багтааснаар үл
[17] бараа урьдахыг монголч нарын санал онолыг
[18] мухраар даган дуурнал үгүй, өдий төдий
[19] зүйлд мангуяа үгийн зүй, үгийн
[20] гарлын судлал, өгүүлбэрийн зүйд шинэ

[Гуравдугаар нүүр]

- [1] шинэ тайлбар оруулж шинэ шинэ саналыг
[2] зоригтой тавьсан байна.

[3] Үүнээс гадна Ринчин гуайн зохиосон
 [4] монгол хэлний зүйн бичиг, баримтаар
 [5] маш баялаг болж уул баримтыг цуглуулахдаа,
 [6] Үе Үеийн монгол хэлний чухам шилдэг
 [7] сайхан жинээг шалгаруулан түүвэрлэж чадсан
 [8] нь урьдахин монголч нарын зохиолд үзэгдээдүй
 [9] амжилт гэж болно.

[10] Ринчин гуай, бас энэхүү монгол хэлний зүйн
 [11] бичигтээ Үе Үеийн монгол найруулга,
 [12] орчуулгын хэлний сайн мууг харшуулан
 [13] судлах муу дутагдалтай найруулга орчуулгыг
 [14] хайр гамгүй нүүмжилсэн нь практик их
 [15] холбогдол учиртай болжээ.

[16] Энэ мэтээр Ринчин гуайн зохиосон
 [17] монгол хэлний зүйн бичиг ерөнхийдөө
 [18] монгол хэлний шинжлэлд маш сонин, үнэтэй
 [19] шинэ том^{*4} бүтээл болжээ.

[20] Гэвч зарим зүйлд ялангуяа үгсийн аймгийн
 [Дөрөвдүгээр нүүр]

[1] тухай, үйл үгийн цагийн тухай, мөн
 [2] өгүүлбэрийн зүйн зарим асуудалд цаашид
 [3] дахин дахин бодуштай зүйл баймаар санагдана.
 [4] Жинээлбэл, Ринчин гуай, гурван цагийн
 [5] ялгамжааг гаргахдаа

[6] а. өнгөрсөн цаг
 [7] 1) өнгөрөн төгссөн цаг. Дагавар -ба, -бай
 [8] 2) өнгөрөн үргэлжилсэн цаг. Дагавар -жухуй.
 [9] э. өдгөө цаг

[10] 1) өдгөө төгссөн цаг. -луга.
 [11] 2) өдгөө төгсөөдүй цаг. -муй

[12] и. ирээдүй цаг
 [13] 1) чухам (сичум) ирээдүй цаг -на, -нам.
 [14] 2) гарцаагүй ирээдүй цаг -юу хэмээн ялгажээ

[15] Ингэж ялгасан нь чухам монгол классик
 бичгийн

[16] хэлний цаг. Халхын аялгуугаар үндсэлсэн
 [17] орчин цагийн монгол хэлний цаг хоёрын
 [18] алин болох нь тодорхой үгүй байна. Монгол
 [19] классик бичгийн хэлний цаг гэтэл -на гэх
 [20] мэтчилэн орчин цагийн монгол ярианы хэлний^{*4}

цагийн дагавар
 [Тавдугаар нүүр]
 [1] ыг оруулжээ. Орчин цагийн монгол ярианы хэлний

- [2] цаг гэтэл -муй,-юу гэх мэтчилэн классик бичиг
 [3] ийн хэлний цагийн дагаварыг оруулжээ.
 [4] Хэлийг шинжлэхэд тухайн хэлний хөгжиж
 [5] ирсэн түүхийг харгалзах нь хэлний шинжээчин
 [6] хүний чухал зүйлийн нэг мөн боловч
 [7] хэл бол нэгэн хэвээр хөдлөшгүй байдаг
 [8] гүй үргэлж хувиран өөрчлөгдөж байдаг
 [9] тул хэлний түүхэн грамматик, орчин цагийн
 [10] нэгэн хэлний грамматикийн хооронд зөрүүтэй
 [11] зүйл зайлшгүй гарах учир тэр бүрийг
 [12] хамаагүй хутган нэгтгэвэл чухам үнэн
 [13] мөн нь мэдэгдэхгүй будлиантахаас*⁶ гадна
 [14] хэрэв энэ зарчмыг бага дундад сургуульд
 [15] үзэх орчин цагийн монгол хэлний зүйд
 [16] баримталбал монголын шинэ утгазохиолын
 хэлийг
 [17] өргөн олны ярианы хэлнээс хэтэрхий холдуулах
 [18] аюулд хүргэж хиймэл шинжтэй болгож
 [19] болох тул,энэ талаар болгоомжлох хэрэгтэй.
 [20] 1950 он. 7 дугаар сарын 15
 [21] №а Лувсанвандан

*1 "Ринчен" гэж бичээгүй. "Ринчин" гэж тодорхой харагдаж байна.
 *2 "Гуай" гэдэг үгийг + + тэмдэг тавин нэмж оруулжээ.
 *3 "хэлний, kelen-ü" гэж бичмээр. Гэтэл "-yin" дагавар маш тод үзэгдэнэ. Яг урдах мөрнөө "kelen-ü, хэлний" гэдэг үг нь харал даа байгаа ба эсвэл "хэлний ёс зүй, kelen-ü yosu jüi", "үг хэл ийн зэвсэг, kele-yin Jebseg" гэж ялгах гэсэн юм болов уу.
 *4 "Том" гэдэг үгийг + + тэмдэг тавин нэмж оруулжээ.
 *5 "Хэлний" гэдэг үгийг + + тэмдэг тавин нэмж оруулжээ.
 *6 "buduliyantuqu, будлиантах" гэдэг үгийг budaliyantaqu гэж бичсэн байна.

Энэ өгүүлэл, шугамтай цааснаа худам монголоор ар өвөргүй бичсэн таван нүүр бичмэл. Нэг нүүрнээ 20 мөр тэй, бүгд 100 мөр, нийт 298 үг (үгийн хэлбэр ороод) тэй байна. Лу багш ер нь ямар толгойт үгсийг их хэрэглэсэн байдаг юм бол гэж, нийт үгсийн ба давтамжийн толийг нь хийж үзэхэд, хамгийн олон нь "В" толгойт үг 42 байлаа. Хамгийн олон давтамжтай үг "хэлний(30)" байна. Нийт 295+3=298 үг, үгийн хэлбэр байна. Үүнд:

V - 42 J - 20 M - 13 N - 10 O - 8 L - 2
 S - 24 U - 18 D - 11 O - 10 U - 7 P - 1
 K - 23 A - 15 Y - 11 C - 10 G - 7 R - 1
 T - 22 Q - 14 I - 10 E - 9 Y - 6 S - 1

Ж Уул өгүүллийн нийт үгсийн ба давтамжийн толь

abiyan-u-1-16, 17, 17.	
angqarun-2-16	amjilta-3-9.
asaγudal-du-4-2.	ayalγu-bar-4-16.
ayimaγ-un-3-20.	aγil-2-7.
alin-4-18.	anggi-1-12.
anu-1-7, 12; 2-7; 3-8; 4-15, 18; 5-5.	arγ-a-bar-1-4.
asaγudal-i-2-6.	ayalγu-yin-1-14.
ayul-du-5-18. ↗	aγil-i-1-9. ↓
-ba-4-7,	grammatik-5-9.
-bai-4-7,	grammatik-un-5-10.
barimta-bar-3-4,	ilangγuy-a-2-19; 3-20.
barimtalbal-5-16,	ilerkei-2-7.
barimta-yi-3-5,	ilyamjiiy-a-yi-4-5.
barum-2-17,	ilyajai-4-14.
basa-2-14; 3-10.	ilyaysan-4-15.
bayaliγ-3-5,	inaγsiki-2-15.
bayiday-5-7, 8.	inggejü-4-15.
bayimar-4-3,	inü-3-14; 5-13.
bayin-a-2-7; 3-2; 4-18.	iregedüi-4-12, 13, 14.
bayiγsan-1-7,	iregsen-5-5.
baγ-a-5-14,	keb-iyer-5-7
baγtayaysan-iyar-2-16,	kele-2-14; 5-7.
bey-e-ben-1-4,	kele-ber-1-5.
bile-1-8,	kele-ber-ben[iyen]-2-11.
biēig-1-11, 13; 2-5, 5;	kelen-eēe-5-17.
3-4, 17.	kelen-ü -1-2, 3, 4, 6, 11, 14, 17, 19;
biēig-degen-3-11.	2-1, 4, 5, 8, 9; 3-4, 6, 10, 12, 17, 18;
biēig-i-2-9, 14.	4-16, 17, 19, 20; 5-1, 3, 4, 5, 9, 10, 15.
biēig-tür-2-14.	kelen-ü-ben-2-12.
biēig-ün-1-2, 17; 4-15, 19;	kele-yi-5-4, 16.
5-2.	kele-yin-2-13.
boduyusitai-4-3.	kemen-4-14.
bol-5-7.	kerbe-5-14.
bolbasurayulqu-dayan-2-9.	kereg-1-8.
bolbasurayulju-2-10.	kereglekü-2-3.
bolbaēu-5-6.	kereg-tei-5-19.
bolqu-4-18; 5-19.	ketürkei-5-17.
bolun-a-3-9.	kimel-5-18.
boluγsan-2-7, 15.	kiγei-1-10.
boljai-3-15, 19.	klassig-4-15, 19; 5-2.
bolju-3-5.	ködelüsi-5-7.
bolγajai-2-13.	kögjiγü-5-4.
bolγaju-5-18.	kümün-1-3.
bolγomjilaqu-5-19.	kümün-ü-2-11; 5-6.
budaliyantaqu-aēa-5-13.	kürgejü-5-18.
bui-2-15.	Lubsangwangdan-5-21.
bölüg-1-16.	-luγ-a-4-10.
bölüg-tür-1-12, 13.	masi-3-5, 18.
bükü-2-16.	maγu-3-13.
büri-yi-5-11.	maγu-yi-3-12.

bütügel-3-19.
bütükü-yin-1-20; 2-2.
dakin-4-3, 3.
dayaburi-4-7, 8.
dayaburi-yi-4-20; 5-3.
dayan-2-18.
dayayan-1-5.
dayuriyal-2-18.
dotur-a-ban-1-11.
dumdadu-5-14.
dutaɣdal-tai-3-13.
duyar-5-20.
dörben-1-11.
edüge-4-9, 10, 11.
edüi-2-18.
egün-e-1-16, 19; 2-1.
egün-e-te-2-4; 3-3;
egün-ü-1-7.
emün-e-1-7.
ene-1-9; 3-16; 5-14; 5-19.
enekü-2-4, 8, 14; 3-10.
eng-1-10.
gebeü-3-20.
gekü-4-19; 5-2.
getel-e-4-19; 5-2.
geJü-3-9.
goul-2-2.
onul-i-2-17.
oruɣulJai-5-1, 3.
oruɣulJu-3-1.
orëin-1-3; orëin-4-17, 20;
5-1, 9, 15.
orëiyulɣ-a-yi-3-13.
orëiyulɣ-a-yin-3-12.
praɣtik-3-14.
qalq-a-yin-1-16; 4-16.
qamiɣ-a-5-12.
qamuruɣsan-2-6.
qarsiɣulun-1-18; 3-12.
qarıyalJaqu-3-5.
qəbsurıyaJai-3-3,
qayir-3-14.
qoladayulqu-3-17.
qolbuydal-3-17.
qoyar-un-4-17.
qoyorundu-5-10.
qubıran-5-8.
qubıyaɣdaysan-1-12.
qudɣun-5-12.
Rinëin-1-1, 8, 9, 10; 2-8;
3-3, 10, 16; 4-4.
sanal-2-17.

medegdekü-5-13.
medegeji-yin-1-7.
metü-ber-3-16.
metütilen-4-20; 5-2.
mongɣol-1-1, 3, 3, 5, 6, 11, 13,
14, 17, 19; 2-1, 4, 5, 8, 11, 11,
14; 3-4, 6, 10, 11, 17, 18;
4-15, 17, 18, 20; 5-1, 15.
mongɣol-un-5-16.
mongɣolëi-2-17; 3-8.
-mui-4-11; 5-2.
muqur-iyar-2-18.
mön-1-5, 14; 2-3; 4-1; 5-6, 13.
-n-a-4-13, 19.
-nam-4-13.
nar-un-2-17; 3-8.
nayirayulɣ-a-3-11, 13.
ner-e-2-10.
ner-e-tei-1-9.
nige-5-6.
nigedgebel-5-12.
nigen-5-7, 10.
nigetü-1-7.
olan-1-14.
olan-u-5-17.
olulta-yi-2-16.
on-5-20.
törü-tei-1-9.
udq-a-5-16.
uduridqal-un-1-13.
uqayan-u-2-15.
uridaki-2-17; 3-8.
uul-3-5.
uëir-5-11.
uëir-tai-3-15.
yariyan-u-4-20; 5-1, 17.
yeke-2-6; 3-14.
yerüngkei-degen-3-17.
yosu-2-12.
yosu-yi-1-20.
-yu-4-14; 5-2.
ögerëilegdeJü-5-8.
ögülebüri-2-2.
ögülebüri-yin-2-1, 20; 4-2.
ögüleJei-1-15, 18, 20.
ögüleJü-2-2.
önggeresgen-4-6.
önggeren-4-7, 8.
örge-5-17.
üge-1-5, 19; 2-11, 13.
ügei-2-18; 3-14; 4-14, 18;
5-7, 8, 11, 12, 13,

- sanal-i-3-1.
 sanaγdan-a-4-3.
 sar-a-yin-5-20.
 sayin-3-12.
 sayiqan-1-9: 3-7.
 sayitur-2-10.
 sigümJilegsen-3-14.
 silideg-3-6.
 silYaraγulun-3-7.
 sin-e-2-20: 3-1,1,1,19: 5-16.
 sinJigetin-5-5.
 sinJilekü-dü-5-4.
 sinJilel-dü-3-18.
 sinJilel-ün-1-4.
 sinJilel-ün-1-6: 2-9.
 sinJileJü-1-5.
 sinJitei-5-18.
 sonin-3-18.
 sudulqu-2-15.
 sudulqu-duni-2-12.
 sudulul-2-20.
 sudulJu-3-13.
 surYaγuli-du-5-14.
 tal-a-bar-5-19.
 talbiγsan-3-2.
 tayilburi-3-1.
 tedüi-2-18.
 tegübürileJü-3-7.
 tegüsügedüi-4-11.
 tegüsügsen-4-7,10.
 temdeg-2-3.
 tere-5-11.
 terigün-1-10.
 teüke-1-14.
 teüken-5-9.
 teüke-yi-5-5.
 todurqai-4-18.
 tomiy-a-yi-2-10.
 tomu-2-7: 3-19.
 toyimu-yi-1-15: 2-2.
 tula-5-9,19.
 tuqai-1-2: 2-3: 4-1,1.
 tuqai-yin-5-4.
 törülki-2-12.
 Jüi-tei-1-18.
 Jüi-yi-1-3,17: 2-12:
 Jüi-yin-1-2,11,16: 2-4,8:
 3-4,10,17: 4-2,3: 5-11.
 Jüyil-dü-2-19: 3-20.
 Jüyil-ün-5-6.
 γadan-a-3-3: 5-13.
 γam-3-14.
 üges-ün-3-20.
 üge-yin-1-19: 2-19,19: 4-1.
 ülü-2-16.
 ündüsülegsen-4-16.
 ündüsün-2-6.
 ünen-5-12.
 ün-e-tei-3-18.
 ürgülJi-5-8.
 ürgülJilegsen-4-8.
 üsüg-ün-1-13: 2-5.
 üy-e-3-6,11.
 üy-e-yin-3-6,11.
 üyile-4-1.
 üJegdegedüi-3-8.
 üJekü-5-15.
 üJekü-dü-2-4.
 ēaγ-4-6,7,8,9,10,11,12,13,
 14,16,17,19: 5-2.
 ēaγ-aēa-2-15.
 ēaγ-un-1-4: 4-1,4,17,20,20:
 5-1,3,9,15.
 ēidaγsan-3-7.
 ēig-2-3.
 ēinaγsida-4-2.
 ēiqula-2-6,10,10: 5-6.
 ēuqum-3-6: 4-13,15: 5-12.
 ēuγlaγulqu-dayan-3-5.
 ēöm-i-2-6.
 Ša-5-21.
 Jarim-3-20: 4-2.
 Jarēim-i-5-14.
 Jayilasi-5-11.
 Jebseg-tei-2-13.
 Jisiyelbel-4-4.
 Jisiy-e-yi-3-7.
 Jokiyal-1-6.
 Jokiyal-du-3-8.
 Jokiyal-un-5-16.
 Jokiyaysan-1-1,6,10: 3-3,16.
 Joriγ-tai-3-2.
 -Juqui-4-8.
 Jörigüü-tei-5-10.
 Jüi-1-19: 2-1,5,19.
 Jüi-dü-2-20: 5-15.
 γaruēaγ-a-4-14.
 γaruγadui-1-7.
 γarYaqu-dayan-4-5.
 γurban-4-4.
 γuwai-2-8.
 γuwai-1-9: 3-10: 4-4.
 γuwai-yin-1-1,10: 3-3,16.
 7-5-20,

Yarqu-5-11.

Yarul-un-2-20.

15 -5-20,

1950 -5-20 байна.

И Нэхэн санахад, Академич Лувсанвандан гуайг 1957 онд монголын зохиолчдын Хорооны Их хурлын үеэр анх харсан шиг санагдана. 1962 онд Шинжлэх Ухааны Академийн ариун босгыг алхаснаасаа хойш, хичээл номынх нь дууг сонсож, хурал хуйд бараадан илтгэл айлтгал, яриа хөөрөөгийн нь сонсож, зуслан зусаалд хамт гарч, унаа зуцаанд цуг сууж, өгүүлэл бичмэлийг нь хэвлүүлэх гэж нааш цааш зөөн зараал зардас болж мөн ч олон удаа уулзаа биз ээ. Тэгэхэд, Лувсанвандан багшийн амнаас: тэнд тийм ном, өгүүлэл гарсан байна, олж үзэв үү, түүнд тэгж бичжээ, чи юу гэж бодож байна, сонин санаа байна шүү гэх мэтээр дандаа л номын тухай яриа гарна даа. Би нь тэр бүгдийг юүгээ мэдэхэв, дэмий л гайхширан, заримыг нь цээжлэн, номын бүртгэл хийж байх зуураа лавлавал, үнэхээр л тийм байна даа. Харин би хэлсэн ярьсан, үзсэн харснаа болж өгвөл цааснаа буулган авдаг байлаа. Заримаас нь сонирхуулая.

Нэгэн зүйл. Нэг өдөр Лу багшийнд, бичсэн өгүүлэлийг нь авахаар очлоо. Дэргэд нь харин Физикийн нэг ном, биологийн нэг ном саяхан үзэж байсан бололтой байж байхыг нь харж байснаа тэссэнгүй асуусан чинь - Хүн байгаль хоёр чинь салжгүй юм шүү. Тэгэхээр байгалийн ухааны үндсэн ном зохиолыг нэг уншаад өнгөрөхөд илүү дэхгүй шүү гэж билээ. Энэ юутай ухаантай хүний үг вэ!

Нэгэн зүйл. 1967 оны 1 дүгээр сарын 17. мягмар гараг. 11.00 МУИС-ийн 2 дугаар байрн 4 давхрын 459 дүгээр өрөөнд Ж. Надмидын <Монгол хэлбичгийн түүхийн зарим асуудал> зохиолыг хэлэлцэх хурал боллоо. Тэр үед Лу багш манай эрдмийн зөвлөлийн гишүүн, маш идэвхитэй, зар хүргэхээр очсон даруйд хүрч ирнэ. Заримдаа цэрдээ байрьсаар, энд тэнд ээ жаахан мохой болгочихсон шиг ч орж ирнэ. Тэр үед чинь эрдмийн зөвлөлийн хурал болоход чинь сүртэй шүү дээ. Лу, Ре, Да гурван академич орж ирээд суучихна, Цэвэл гуай, Содном гуай гээд л томчуул нийлчихнэ, хөөр гөлцгөөгөөд л, тамхи бие биеэсээ гуйж татаад л, ха жуугаас нь харж суухад сонин байдагсан, Одоо нэхэн бодоход ч мөн сайхан санагдаж байна. Тэгээд дандаа л ном ярина даа. Эл хурал дээр Лувсанвандан багш Ре багшаас - Ринчин гуай та, уйгуржинийг 8 дугаар зууны үед авсан гэсэн. Хятан бичиг 9-10 дугаар зууных. Тэгэхээр энэ чинь зөрчилдөж байгаа юм биш үү? гэхэд Ре багш - Хятан доторхи омог ясыг бид мэдэхгүй байна ш дээ гэж өчихөд. Лу багш - Тэгвэл хятан бичиг, уйгуржин хоёр зэргэцэж байсан гэвэл ямар байна? Тэр үед урд хэсэг

нь өөр соёлтой, умардах нь уйгуржин соёлтой байж болох биш үү? гэхэд, Ре багш - зэргэцсэн байж болох байна гэж хариулж байлаа.

Лу багшийн энэ хэлсэн үг энгийн үг биш. Тун нухацтай, холын бодолтой үг байлаа.

Зарим монголч нар Гурван голын монголчууд, тухайлбал, Чингисийн монголчууд бичиг үсэггүй, харанхуй бү дүүлэг байсан гэж илэн далангүй бичиж байсны хариулт байжээ гэж үзэх ёстой бус уу. Алсын хараа гэж ийм байдаг аж!

Нэгэн зүйл. 1967.11.03. 15 цагт УННС-гийн 106 дугаар танхимд эрдэм шинжилгээний хурал болж, тэргүүлэгчдийн ширээнд зүүн гар талд Поуха, дунд нь Ре багш, тэгээд Лу багш байр эзэлсэн байлаа. Энэ хуралд Лу багш <Монгол хэлний зарим дагаврын тухай> гэсэн илтгэл тавилаа. Лу багшийг самбар дээр юм бичиж, ярихын алдад Ре багш, Поуха нар суудлаасаа босч урд талын эгнээнд ирж суугаад илтгэлийг сонсов. Лу багш ийнхүү гадна дотнын том эрдэмтдийг хүртэл босч сууж чагнатал нь сонирхолтой юм ярьдаг их хүн байлаа. Ярьж байгаа зүйл нь товч тодорхой, түүндээ итгэлтэй гэж яана.

Нэгэн зүйл. 1968.01.05. Баасан гараг. 16.45. Энэ өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар 1968 онд хэвлэлд шилжүүлэх бүтээлийг хэлэлцэв. Ре багшийн <Хамниган аялгуу> гэдэг зохиолыг оруулах эсэх талаар ярилцахад Э.Вандуй гуай - Нэр тохирохгүй байна. Монголд хамниган хэл ч гэж байхгүй, хамниган үндэстэн ч гэж байхгүй гэлээ. Тэгэхээр Ре багш - уг нь <Монгол хамниган хэл аялгуу> гэж гарчиг тавьж бичсэн юм гэв. Чимээгүй чагнаж суусан Лу багш - Зөв байна гэж хэлэв. Вандуй гуай - Тэгвэл оросоор яаж орчуулахав гэлээ. Ре багш - Би оросоор орчуулах бодолгүй байна. Өө, би оросоос хуулаагүй гээд орчуулж өгсөнгүйд Лу багш чанга гэгч инээд алдаж билээ. Эцэст нь, Лу багшийн зөвшөөрснөөр тогтож, Лу багшийг редактораар томилж, хэвлэлд шилжүүлэх болсон. Ер нь Лу багшийг байхад түүний амыг л хардаг байсандаа. Ийм л нуруутай, нэг дуугархаараа ултай юм хэлдэг эрдэмтэн байлаа.

Нэгэн зүйл. 1969.12.20. Бямба гараг. 12.00. УННС-гийн 106 дугаар танхимд Дөрвөлжин үсгийн 700 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болж Ре багш, Лу багш нар үг хэлж, дөрвөлжин бичгийг магтаж магтаж суухад Лувсандэндэв гуай босч очоод - Дөрвөлжин үсгийг зохиож тархаах гэж нэн их хүч хөрөнгө зарж сацсан яв

дал бол уйгуржин монгол бичгийн тархацад саад болсон юм. Дөрвөлжин үсэгт зарсан шигээ их хүч гаргаж уйгуржин бичгийг тархаах гэж оролдсон бол илүү амигтай болох байсан. Галидас модны мөчир дээр суугаад мөчрөө хөрөөдөж байлаа гэдэг шиг Ре багш, Лувсанвандан гуай хоёр харин сая босоод дөрвөлжин үсгийг магтаж, түүний монголын соёлд учруулсан хорыг хэлэлгүй, хөрөөний хоёр талаас барьж нэг нэг татаад орхих шиг боллоо хэмээн хэлж байж билээ. Урьд манайхны хурал дандаа л ийм мэрхүү эрдэм шинжилгээний маргаантай болдог, хүнд нэг юм бодогдуулдаг байж билээ. Мэргэдийн мэтгэлцээнээс сурах зүйл бидэнд энэ мэт их байсныг хэлэх юун.

Монголыг маань Ухааны Тэнгэр ивээх болтугай.
2000.01.09.